

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ

ХОРООНЫ ТОГТООЛ

2009 оны 1 дүүгэр
сарын 29-ны өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Хорооны орон тооны бус гишүүнд олгох урамшууллын
хэмжээг шинэчлэн тогтоох тухай

Монгол Улсын Их Хурлын 2006 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан “Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм”-ийн 2.2.4, Санхүүгийн зохицуулах хорооны 2009 оны I дүгээр тогтоолоор батлагдсан “Хорооны орон тооны бус гишүүнд урамшуулал олгох журам”-ын 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнд сар бүр олгох урамшууллын хэмжээг 200,000 /хоёр зуун мянган/ төгрөгөөр тогтоосугай.

2. Орон тооны бус гишүүнд олгохоор тогтоосон урамшууллыг Хорооны төсвийн холбогдох зардлаас олгож байхыг Ажлын алба /О.Ганбат/-нд даалгасугай.

ДАРГА

Д. БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ